

Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалав

ОХУ-ын Улаан-Үүд хотын Дорнод Сибирийн технологи удирдлагын улсын их сургуулийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл дээр 2014 оны 10 сарын 23-д Олон улс судлалын хүрээлэнгийн ЭШТА, доктор (Ph.D), профессор Авирмэдийн Даваасүрэн «Монгол Улсын эдийн засгийг газар нутаг орон зайн хувь тэгш хөгжүүлэх онол ба практика» сэдвээр эдийн засгийн шинжлэх ухааны докторын Sc.D зэрэг хамгаалав.

Тус докторын диссертацийн ажлын гол агуулга нь гадаадын эрдэмтдийн онол, арга зүйн асуудлууд, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын бүсчилсэн хөгжлийн туршлагыг судалсны үндсэн дээр Монгол улсын нийгэм, эдийн засаг, цаг агаар, газар нутгийн байршилтын онцлогууд, эдийн засгийн потенциалыг тооцоолж, бүсүүдийн тодорхой эдийн засгийн салбарт төрөлжиж дагнах замаар байгалийн баялаг, уул уурхайн болон мал аж ахуйн түүхий эдэд гүн гүнзгий боловсруулалт хийж бэлэн экспортыг дэмжсэн хүний хөгжилд тулгуурлсан эдийн засгийг хөгжүүлэх шинэ загварыг боловсруулан, бүс нутгуудад аж үйлдвэр-инновацийн кластеруудыг байгуулах, 2026 он хүртэлх эдийн засгийн хөгжлийг прогноз хийсний үндсэн дээр хөгжлийн урт хугацааны стратегийг сценарийн хамт боловсруулан хэрэгжүүлэх, бүсүүдийн хөгжлийн чиглэлүүдийг тодорхойлох замаар хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, үйлдвэрлэлийн хэрэгслэл, санхүүгийн нөөцийн, хүн амын Улаанбаатар болон бусад хотуудад зохисгүй төвлөрөлийг бууруулахад хүний хөгжлийг онцгой дээшлүүлэхэд оршиж байна.

Энэхүү эдийн засгийн шинжлэх ухааны докторын диссертацийн удирдагчаар ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн эдийн засаг, эрх зүйн улсын их сургуулийн профессор эдийн засгийн шинжлэх ухааны доктор Sc.D ОХУ-ын Ш/У-ны гавьяат ажилтан Виктор Иванович Самаруха, Албан ёсны 1-р шүүмжлэгчээр Москва хот дахь ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, Ш/У-ны доктор Sc.D профессор, ОХУ-ын ШУА-ийн сурвалжит гишүүн Дмитрий Евгеньевич Сорокин, Албан ёсны 2-р шүүмжлэгчээр ОХУ-ын Эрхүү хотын Сибирийн эдийн засаг, эрх зүйн академийн дэд захирал, Ш/У-ны доктор Sc.D, профессор Владимир Иосифович Буньковский, Албан ёсны 3-р шүүмжлэгчээр ОХУ-ын Буриад улсын ХАА-н академийн тэнхмийн эрхлэгч, Ш/У-ны доктор Sc.D, профессор Ираида Гомбоевна Сангадиева нар ажиллаж шүүн тунгааж уг судалгааны ажил нь ОХУ-ын эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэгт тавигдах шаардлагыг бүрэн хангасан гэсэн саналаа ирүүлсэн байна. Түүнчлэн уг диссертацийн хураангуйг ОХУ-ын төрийн өмчийн нийт 10 сургуулиудын эрдмийн хамт олон хэлэлцэж, нэр хүнд бүхий эрдэмтдийн зүгээс ОХУ-ын Боловсрол, ШУ-ын Яамны дэргэдэх докторын зэрэг олгох дээд комиссиос (ВАК) тавигдах бүх шаардлагыг бүрэн хангасан учир эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэг горилогч Монгол Улсын иргэн Авирмэдийн Даваасүрэнд ОХУ-ын ШУ-ны докторын зэргийг олгох нь зүйтэй гэсэн санал дүгнэлтийг ирүүлсэн байна.

Уг диссертацийг Монгол улсын ШУА-ын дэд ерөнхийлөгч, эдийн засгийн Ш/У-ны доктор Sc.D, профессор академич Т.Дорж, “Этүгэн” дээд сургуулийн удирдах зөвлөлийн дарга, эдийн засгийн Ш/У-ны доктор Sc.D, профессор академич С.Нямзагд нар Монгол Улсын эдийн засгийг орон зайн хувьд зохион байгуулж хөгжүүлэх асуудал нь хүн амын зохицуулалтгүй нүүдэл ихсэж орон нутаг эзгүйрч байгаа үед улс орны эдийн засгийн газар нутгийн хувьд тэгш тэнцүү хөгжлүүэх санаа нь шинэлэг бөгөөд цаг үеэ олсон томоохон ШУ-ны судалгааны ажил болжээ гэсэн дүгнэлтээ албан ёсоор бичгээр ирүүлсэн байна.